



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2018 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 1/211

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Булган сумын 5, 16 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаартай зөвлөмжийн дагуу “Булган барилга” ХХК-тай 54 422 537 /тавин дөрвөн сая дөрвөн зуун хорин хоёр мянга таван зуун гучин долоо/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай

2. Ажлын гүйцэтгэлд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Булган барилга” ХХК /С.Сэр-Од/-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг аймгийн төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ